

ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

Үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй дотоод хүчин зүйлсийн тухайд

Довчингийн Мягмар

Доктор (Sc.D), профессор, шинжээчийн хэсгийн ахлагч, igsmyagmar@gmail.com
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл

Хураангуй

Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэсэн иргэний ардчилсан нийгэм байгуулах их шилжилтдээ багагүй амжилт оллоо. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог байгуулан бэхжүүлэх ажил алгуур боловч урагшилсаар байна.

Гэвч Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг төрийн бодлогоор нэгтгэн хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих үр дүнтэй механизм бий боллоо гэж хэлэх бас хараахан болоогүйн дээр Монгол Улсыг хүрээлсэн гадаад орчин, дотоод нөхцөл байдал, түүнчлэн цэргийн хэргийн онол, практикт өнгөрсөн хугацаанд багагүй өөрчлөлт орж, энэ нь сүүлийн жилүүдэд улам бүр эрчимжиж байна.

Монгол Улсын гадаад орчин, дотоод нөхцөл байдал, түүнчлэн цэргийн хэргийн онол, практикт өнгөрсөн хугацаанд багагүй өөрчлөлт орж, сүүлийн жилүүдэд улам бүр эрчимжиж байна. Ялангуяа Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй дотоод үүдэл сэдэл бүхий олон шинэ хүчин зүйл бий боллоо. Иймээс 2010 онд батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” хэмээх баримт бичгийг тодотгон шинэчлэх, энэ хүрээнд үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй гадаад, дотоод нөхцөл байдал, хүчин зүйлсийг судлан тодорхойлж, дүн шинжилгээ хийх, улмаар үнэлэлт дүгнэлт өгөх зайлшгүй шаардлага үүсээд байна.

Түлхүүр үгс: Аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагаа, дотоод аюулгүй байдал, аюулгүй байдлын хүчин зүйлс, аюулгүй байдлын хууль тогтоомж, батлан хамгаалах бодлого, цэргийн аюулгүй байдал

Үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй дотоод нөхцөл байдал, хүчин зүйлс

Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэсэн иргэний ардчилсан нийгэм байгуулах шилжилтийн хугацаанд багагүй ахиц дэвшилд хүрсэн билээ. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог байгуулан бэхжүүлэх ажил алгуур боловч урагшилсаар байна. Гэвч

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг төрийн бодлогын түвшинд нэгдмэл байдлаар хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих үр дүнтэй механизм бий болж, бүрэн төлөвшсөн гэж үзэхэд хараахан эрт байна.

Нэг. Төрийн байгууллын тогтвортой байдал алдагдаж болзошгүй нөхцөл байдлын талаар

Төрийн байгууллын тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй эрсдэлийн магадлал зарим талаар бодитой байна. Төв суурин газар, орон нутаг хоорондын хөгжлийн тэнцвэргүй байдал, нийгмийн тодорхой бүлэг, хэсгүүдийн орлогын ялгаа хэт даамжрах нь хүн амын дунд тогтворгүй байдлыг үүсгэж, улмаар төрийн тогтвортой байдалд аюул учруулж болзошгүй юм. Учир нь энэ хэт их ялгаа нэг талаас чинээлэг, нөгөө талаас ядуу хүмүүсийн хооронд зөрчил үүсгэх, түүнийг шийдвэрлэх зорилгоор төр засгаас хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийн арга хэмжээ нь төдийлөн амжилтад хүрэхгүй бол ард түмний дунд хуулийн бус арга хэрэгслийг хүсэмжлэх уур амьсгалыг бий болгох аюултай байдаг. Хэрвээ ийм байдал үүсвэл улс төрийн тогтвортой байдал алдагдаж, улмаар төрийн байгуулалд итгэх итгэл сулрахад хүргэж болно. Гэтэл чөлөөт сонгуулиар байгуулагддаг ардчилсан тогтолцоот төрийн байгуулал нь Монгол Улсыг бусад улс оронтой эрх тэгш харилцаа хөгжүүлэх, аюулгүй байдлаа бэхжүүлэхэд тулгуур болж буй гол хүчин зүйл билээ.

Монгол Улс Үндсэн хуульдаа төрийн байгуулалтаа “Парламентын бүгд найрамдах улс” гэж томъёолсон нь төрийн дээд эрх мэдлийг нэг, эсхүл хэсэг бүлэг хүний эрх мэдэлд олгохоос зайлсхийсэн, том гүрнүүдийн хооронд оршиж байгаа жижиг орны хувьд төрийн бодлогыг олон түмний санаа бодол дээр тулгуурлан явуулж байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгын илэрхийлэл юм. Үүний зэрэгцээ сүүлийн үед ард түмний зүгээс парламентад ямар нэг хэлбэрээр итгэл алдрах болж улмаар засаглалын өөр хэлбэрийг, эсхүл УИХ-ын эрх мэдэлд тодорхой хэмжээний хязгаарлалт хийхийг хүсэмжлэгчдийн тоо нэмэгдэж байгаа нь нийгмийн томоохон маргаан, тэмцэл, зөрчил, сөргөлдөөнийг үүсгэж улмаар энэ нь улс орны улс төрийн амьдралд хүчтэй нөлөө үзүүлэхээр байна. Үүнтэй уялдаатайгаар төрийн зарим эрх мэдлийг төвөөс орон нутагт шилжүүлэх шаардлага нэмэгдэж, төрийн бус байгууллагууд, иргэний хөдөлгөөнүүдийн төр, засагт шахалт үзүүлэх арга механизм өөрчлөгдөж, хэмжээ далайц нь өсөх хандлагатай байна.

Хоёр. Нийгмийн бухимдал ноцтой гүнзгийрэх болон улс төрийн экстремизм үүсэж болзошгүй нөхцөл байдлын тухайд

Дотоодын аюулгүй байдалд нөлөөлж болох нэг шинэ гэж хэлж болох эрсдэл нь манай улсад өнөөг хүртэл тогтвортой, сайн засаглалын баттай суурь тавигдаж чадаагүй байгаа явдал юм. Монгол Улсын улс төрийн аюулгүй байдал нь олон зууны туршид үнэн чанартаа төрт ёсыг дээдэлж, үүнийхээ тулд эвлэрэн нэгддэг байсан монгол түмний түүхэн уламжлалд тулгуурлаж ирсэн билээ. Үүний зэрэгцээ энэ тогтвортой байдал нь ардчиллын үнэт зүйлсийг үндсэндээ бүх ард түмэн хүлээн

зөвшөөрөх болсонтой ихээхэн хамааралтай болох нь сүүлийн жилүүдэд харагдаж байна. Гэхдээ зөвхөн үндэсний эх оронч сэтгэлгээ, ардчиллын үнэт зүйлсийг эрхэмлэх нь удаан хугацааны тогтвортой байдлыг хангаж чадахгүй, түүнчлэн эдгээрийг хослуулах нь ихээхэн амаргүй зүйл болохыг өнөөгийн болж буй олон хямралт үзэгдэл улам бүр тодорхой харуулсаар байна.

Ер нь хүн амын цөөнгүй хэсгийг хамарсан ядуурал, нийгмийн шударга бус байдал, авлига, хүнд суртал зэрэг нь эцсийн дүндээ улс төр, эдийн засгийн зөв мэргэн бодлого дутагдсанаас үүдэн гардаг бөгөөд дотоод улс төрийн амьдралд хүчтэй нөлөөлж, улс төрийн экстремизмийн хэлбэр агуулсан зөрчил, сөргөлдөөнийг үүсгэх магадлалыг бий болгодог.

Монголын дотоод улс төрийн амьдралд ийм төрлийн аюул үүсэж болох магадлал бодитой байгааг 2008 оны долоодугаар сарын 1-нд болсон үйл явдал тодорхой харуулсан билээ.

Ойрын жилүүдэд аюул учирч болзошгүй үйл явдлын таамаглалаар бол дотоод улс төрийн амьдралд нийгмийн шударга ёсны төлөөх иргэдийн зүй ёсны тэмцэл хэт хувьсгалжсан, улс төрийн экстремизмийн хэлбэрт шилжиж болзошгүй байгаа явдал юм. Энэ нь өмнөх нийгмээ санагалзсан хүн амын ахмад гэж хэлж болох тодорхой хэсэг, ажилгүйдэл, ядууралд нэрвэгдсэн иргэд, боловсролын гадна үлдсэн залуучуудын дунд түгээмэл болсоор байна. Нийгмийн шударга ёсонд итгэл алдарсан болон төр засагт итгэхээ больсон хүмүүсийн тоо сүүлийн жилүүдэд тодорхой хэмжээгээр өссөн судалгаа байгаа бөгөөд ийм байдал цаашид ч нэмэгдэж болох юм.

Ноцтой гол асуудал нь нийгэмд эзэлж байгаа байр сууриндаа сэтгэл дундуур, бүхнийг эсэргүүцэгч ахмад үеийн хэсэг бүлэг хүмүүсийн зэрэгцээ залуусын дунд бүх шатны дарга нар болон мөнгөтэй, хөрөнгөтэй хүмүүст таагүй хандах явдал багагүй дэлгэрэх болсон явдал юм. Тэд сүүлийн үеийн зарим улс төрчийг Монгол Улсыг, түүний дотор, газар нутаг, ахмад үеийнхний хүч хөдөлмөрөөр хуримтлуулсан материаллаг баялгийг үрэн таран хийсэн, зарим зүйл дээр барууныхны дуу хоолойг хэт дуурайгчид болсон гэж буруутгаж байна. Мөн улс орны эдийн засгийн амьдрал, бага, дунд бизнест зарим нэг гадаад улсын иргэдийн оролцоо ихээхэн нэмэгдэж байгаад дургүйцэж байгаа юм. Энэ бүхэн нь эцсийн дүндээ Монголын ард түмэн өөрийн газар нутаг, нийгмийн болон байгалийн баялгийнхаа эзэн байх эрхээ бусдад аажмаар булаалгаж улмаар үндэсний аюулгүй байдлаа алдаж эхэлж байна гэсэн сэтгэлгээг нийгмийн дунд бий болгосоор байна.

Эдгээрийн дотроос анхаарал татаж байгаа өөр нэг зүйл бол нийгэмд хүчтэй өрнөж буй байгаль орчин, орон нутгийнхаа газар нутаг, бэлчээр, усаа хамгаалах хөдөлгөөнүүд болон Улаанбаатарт эрчимтэй өрнөж байгаа газрын төлөө маргаанууд нь төрөөс энэ тал дээр шийдвэртэй арга хэмжээ авахгүй байх тохиолдолд улс орны улс төрийн тогтвортой байдалд улс төрийн агуулгатай эрсдэл сорилт үүсэх бас нэг эх сурвалж болж магадгүй байгаа явдал юм. Хэдийгээр эдгээр хөдөлгөөн, маргаан, тэмцэл нь үндсэндээ шударга гэж хэлж болох зорилгыг агуулсан болох нь

тодорхой боловч цаана нь асуудлыг хуулийн бус аргаар шийдвэрлэх, өөр хоорондоо тооцоо бодох, хууль бус амар аргаар хөрөнгө мөнгө олж авах, гадаадын хөрөнгө оруулагчдын эсрэг туйлширсан тэмцэл явуулах зэрэг санааг хадгалсаар байгаа нь ажиглагдаж байна. Одоохондоо тэдний тоо, нөлөө харьцангуй бага бөгөөд олны дэмжлэгийг ч төдийлөн сайн авахгүй байгаа юм. Гэвч тэдний үзэл бодол, ялангуяа хэсэг бүлэг ахмад, зарим малчин, оюутан, залуус, орлого багатай иргэдийн дунд ихээхэн дэмжлэг хүлээсээр байгааг анхаарах хэрэгтэй юм.

Залуусын хэт туйлшрах хандлага, түүнчлэн хууль эрх зүйн боловсрол дутмаг байгаа нь байгаль хамгаалагчид болон хууль сахиулагчидтай хийж байгаа сөргөлдөөнтэй хослох юм бол олныг хамарсан хэт даварсан шинжтэй экологийн хөдөлгөөн үүсгэдэг болохыг олон улсын туршлага харуулж байна. Барууны орнуудын туршлагаас үзэхэд ийм хөдөлгөөн нь хүч хэрэглэх, экологийн аюул учруулж болзошгүй байгууламжуудад халдах, тэдгээрийг эзлэн авч барьцаалах, хүн амыг эмх замбараагүй байдалд турхирах зэрэг шинж чанартай болж хувирах нь олонтоо тохиолдсон. Өөрөөр хэлбэл: экологийн хөдөлгөөн нь экологийн фашизм болох магадлал өнөөгийн олон улсын практикт ихээхэн түгээмэл болоод байна. Энэ нэр томъёог Баруун Европын зарим орны улс төрийн хэллэгт аль хэдийнээс хэрэглэж эхэлсэн бөгөөд хэт туйлширсан байгаль хамгаалагчид буюу эко фашистууд нь улс төрийн хүрээний хэт даврагсадтай ойртон нягтарч, улс орны улс төрийн амьдралд ноцтой эрсдэл дагуулах тохиолдол цөөнгүй гарсаар байна. Манай оронд энэ төрлийн үйл явдлын эхний шинж тэмдгүүд аль хэдийнээ мэдрэгдэж эхэлсэн бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчдын болон бие биеийнхээ эд хөрөнгөд халдах, эвдэж сүйтгэх, тэр ч байтугай галт зэвсэг хэрэглэн буудаж танхайрсан явдал гарсан. Хууль сахиулах байгууллагын хайхрамжгүй байдал болон иргэдийн өөгшүүлсэн хандлага нь уг асуудлыг даамжруулах нөхцөл болж байна. Ойрын ирээдүйд улс төрийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй бас нэг эрсдэл нь олныг хамарсан иргэний хөдөлгөөнүүд хэт туйлширсан шинж рүү хэлбийж болзошгүй явдал юм. Одоогийн иргэний хөдөлгөөнүүд хэдэн жилийн өмнөхтэй харьцуулахад улс төрийн тогтвортой байдалд ноцтой эрсдэл дагуулах хэмжээнд хүрээгүй байна. Гэвч эдгээрийн дотроос хэт түрэмгийлэх байр суурь баримталдаг нэг хэсэг тасарч гарах, эсвэл хэт зүүний үзэл баримтлалтай нам, хөдөлгөөнүүд нэгдэж нягтрах болон эдгээрийн хосолмол хэлбэр үүсэх нөхцөлд нийтийг өргөнөөр хамарсан хэт даврах хэлбэрийн нам, хөдөлгөөн гарч ирэх магадлал бодитой байгаа юм.

Ер нь ойрын жилүүдэд үндэсний үзэлт радикал байгууллагууд, хэт даврах үзэл суртлыг номлогчид, байгаль орчин болон өөр өөрийн сум, багийнхаа газар нутгийг хамгаалагчид, даяаршлыг эсэргүүцэгчид, дэлхийг өөрчлөх зорилго бүхий “хувьсгалч” байр сууриа хадгалсаар байгаа хэт коммунист үзэлтнүүд ойртон нийлж нөлөө бүхий улс төрийн томоохон хүчин болон хувирч магадгүйг огт үгүйсгэж болохгүй юм. Нийгэм, улс төрийн хөгжлийн өнөөгийн ээдрээтэй, тогтворгүй байдал үргэлжилсэн хэвээр байвал дээр дурдсан улс төрийн хүчин сонгогчдын олонхын дэмжлэгийг авахуйц эвсэл, холбоо байгуулах магадлалтай байна. Энэ нь эцсийн дүндээ хэт туйлширсан, магадгүй хэт даврах үзэл

баримтлалтай хүчин засгийн эрхэнд хүч хэрэглэхгүйгээр гарах буюу “өнгөт хувьсгал” хийх боломжийг бий болгох талтай.

Төрийн эрхийг хууль бусаар авахыг буюу улс төрийн хэт даварсан хөдөлгөөнд уриалагчдын дуу хоолой одоогоор олны дунд төдийлөн дэмжлэг авахгүй байгаа нь төөрөгдөлд оруулах үндэслэл болж, тайвшруулах шалтгаан байж болохгүй. Хэрэв дотоод улс төрийн байдал хурцадсан нөхцөлд ийм төрлийн хүчин богино хугацаанд зохион байгуулалтад орж, нийгмийн олонхын дэмжлэгийг хүлээн, үндсэрхэг болон хэт туйлширсан бүлэглэлүүдийн үзэл санааг хэрэгжүүлэх хэрэгсэл болох эрсдэлтэйг олон улсын жишээ харуулсан. Ийм байдал үүсгэхгүй байх хамгийн гол нөхцөл нь юуны өмнө сайн засаглалыг бэхжүүлэх, эдийн засгийг эрүүлжүүлэх, нийгмийн тулгамдсан асуудлуудыг иргэдэд ашигтайгаар шийдвэрлэх, түүний дотор шударга ёсыг хангах, иргэний нийгмийг хөгжүүлэх, авлига, гэмт хэрэгтэй бүхэлд нь шийдвэртэй тэмцэх явдал юм. Хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал нийт иргэдийн итгэлийг хүлээх, тэдэнтэй ойр дотно харилцааг өргөжүүлэх, шинэ төрлийн өөриймсөг холбоо тогтооход чиглэсэн тодорхой алхмууд нь эерэг үр дүн үзүүлэх болно.

Гурав. Үндэстэн ястан, шашин шүтлэг хооронд зөрчил сөргөлдөөн үүсэж болзошгүй нөхцөл байдлын талаар

Орчин үед үндэстэн ястан, шашин шүтлэг хоорондын мөргөлдөөнийг олон улсын нөхцөл байдал хурцдаж байгаагийн нэг шууд үр дагавар гэж үзэх хандлагатай байна.

Дэлхий нийтэд болж буй энэ төрлийн үйл явдал улам бүр өргөжиж, хамгийн тогтвортой гэгдэж байсан Европын орнуудыг хүртэл хамрах болсон нь үүнээс зохих сургамж авч, төр засаг, ард иргэд, үүний дотор үндэсний олонх, цөөнхийн аль алины төлөөлөгчид үндэсний эв нэгдлээ сахин хамгаалахад онцгой анхаарах ёстойг сануулж байна.

Ер нь үндэстэн, ястан болон шашин хоорондын зөрчил үүссэн тохиолдолд дотоод улс төрийн нөхцөл байдал хурцдаж, ноцтой аюул, сөргөлдөөнд хүрдэг болохыг олон улсын жишээ харуулсаар байна. Үүний зэрэгцээ ийм төрлийн аюул, эрсдэлийг бий болгож болзошгүй шашны байгууллагуудын дотоод үйл ажиллагаанаас гадна зөрчил, сөргөлдөөнийг өдөөх гадаад хүчин зүйлс, дотоодын улс төрийн тодорхой бүлэг, хүчний хатгалга, мөн төрөөс шашин, сүм хийдийн талаар баримталж буй бодлогын санаатай болон санамсаргүй алдаа, дутагдлыг тооцон үзэх шаардлагатай юм. Төр, үндэстэн хоорондын харилцаан дахь салан тусгаарлах хөдөлгөөн мэт сөрөг хандлагуудын эсрэг улс орон болгон удаан хугацааны, цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх замаар асуудлыг шийдвэрлэж ирсэн. Ийм бодлогын үндсэн агуулга нь аливаа улсын бүх үндэстэн, ястан тус тусын үндэсний онцлог, ахуй хөтлөх арга ухаан, нийгэм, соёл, шашин шүтлэгийнхээ уламжлалыг хадгалсан тэгш эрхтэй байж, хөгжил дэвшилд хүрэх таатай нөхцөлийг бүрдүүлэх, тэдгээрийн хооронд нэг улсын

иргэдийн ахан дүүсийн харилцааг хөгжүүлэхэд чиглэсэн өргөн хүрээтэй, эрх зүйн хатуу зохицуулалт, баталгаатай, иж бүрэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршдог.

Дөрөв. Шүүх засаглалын болон хууль сахиулах байгууллага доройтож болох нөхцөл байдлын тухайд

Улс орны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийн эсрэг үр дүнтэй тэмцэхэд аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд, ялангуяа шүүх засаглал болон хууль сахиулах байгууллагын чадавх, бие даасан байдал, шударга ажиллагаа онцгой чухал үүрэгтэй байдаг. Эдгээр байгууллага үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чадвараа алдах, үйл ажиллагаа сулрах нь тухайн улсын улс төрийн салбарт гаднаас нөлөөлөх, аюул учруулах эрсдэлийг нэмэгдүүлэх нэгэн хүчин зүйл болдог. Энэ нь дотоод болон гадаад аль алинд нь сөрөг үр дагавар дагуулах магадлалтай юм.

Шүүх засаглал, хууль сахиулах байгууллагын чадавх суларснаас хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын хүч сулрах, ард түмэн, иргэдийн төрдөө итгэх итгэл алдрах, цаашлаад улс төрийн тогтворгүй байдал үүсэх, хууль бус үйл ажиллагаа, гэмт хэрэг газар авч, хараа хяналтаас гарах зэрэг хэлбэрээр өргөждөг байна. Байгууллагын хүч чадал суларснаас үүдэн үүсэж болох дээр дурдсан аюул нь үндсэндээ дотоод улс төрийн амьдралд хамаарч болох юм. Учир нь эдгээрээс сэргийлэх, ийм нөхцөл байдал үүссэн тохиолдолд засаж залруулах нь төр засгийн зөв мэргэн оновчтой бодлого, улс орны дотоод нөөц бололцоог үр дүнтэй дайчлах болон улс төрийн удирдлагын дотоод шинж чанарыг зөв голдиролд нь оруулах замаар шийдвэрлэгддэг.

Төр, нийгмийн шилжилтийн эхэн үед буюу 1990-ээд оны эхэн хагаст Монгол Улсад болсон олон талт хямралын нэг тод илрэл, үр дүн нь аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий, түүний дотор Зэвсэгт хүчин, шүүх засаглалын болон хууль сахиулах байгууллагууд ихээхэн суларсан явдал байсан юм. Эдгээр байгууллагад маш том цохилт авчирсан зүйл бол юуны өмнө ОХУ-ын дэмжлэг, тусламж бүрэн зогссон явдал байлаа. Үүний дараа улс орныг бүхэлд нь хамарсан эдийн засгийн хямрал, түүнчлэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хамгаалах бие даасан тогтолцоог цоо шинээр бүрдүүлж хөгжүүлэх онолын үндэслэл, үзэл баримтлал, дадлага туршлага тэр үед үндсэндээ байгаагүй нь ихээхэн бэрхшээл учруулсан билээ.

Шүүх засаглал, хууль сахиулах байгууллагад үүссэн дээрх хямралын үр дагавар олон хэлбэрээр одоо хүртэл үргэлжилсээр байна. Хэдийгээр сүүлийн жилүүдэд төр засгаас энэ асуудалд илүү анхаарал хандуулж байдал зарим талаар сайжирч байгаа хэдий ч Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг бүрэн хэмжээгээр, найдвартай хамгаалах хэмжээнд хүртлээ өөрчлөгдөх нь ирээдүй цагийн асуудал хэвээр байгааг энэ чиглэлээр явуулсан олон тооны судалгаанууд харуулсаар байгаа юм.

Дээр дурдсан зүйлсийг үндэслэл болгон Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл сорилтуудыг нэгтгэн тодорхойлж, улс төр, эдийн засаг, нийгмийн үндсэн салбараар нь ангилан авч үзлээ. Үүнд:

Улс төрийн салбарт:

- Улс төрийн хямрал үүсэх магадлал хадгалагдсаар байна. Энэ нь улс төрийн намуудын үйл ажиллагаа төдийлөн төлөвшихгүй, сайн засаглал бий болох үйл явц удаашралтай, төрийн захиргааны бүх түвшний удирдлагад мэргэжлийн бус, шударга биш арга барил тодорхой хэмжээгээр зонхилсоор байгаа зэрэг олон хүчин зүйл, шалтгаанаар илэрч буй бөгөөд эцсийн дүндээ төрийн байгуулалт, засаглалын хөгжлийн чиг баримжааны талаар тодорхойгүй байдлыг үүсгэж, улмаар үндэсний аюулгүй байдалд ч сөргөөр нөлөөлж болзошгүй байна.
- Авлига, улс төрийн удирдлагын түвшний хууль бус, шударга биш үйлдлүүд, түүний дотор УИХ-ын гишүүд болон бусад төрийн өндөр албан тушаалтнуудаас ёс зүйн зөрчил гаргах явдал цөөнгүй байгаа зэрэг олон тооны ноцтой алдааны улмаас иргэд улс төрийн намд улам бүр итгэл алдрах болж, тэдний нэр хүнд иргэдийн дунд унах болсноос үүдэн засаглалын өөр хэлбэр, шинэ хүмүүсийг хүсэмжлэгчдийн тоо эрс нэмэгдэн улмаар 2028 онд явагдах УИХ-ын сонгууль улс төрийн ноцтой хямралын нөхцөл байдалд болох, тэр ч байтугай ямар ч байдлаар гарсан үр дүнг нь хүлээн зөвшөөрөхгүй байх, эсвэл энэ сонгууль тасалдаж болох шинж тэмдэг мэдрэгдэж эхэллээ.
- Үндсэн хуулийн хямрал гэж хэлж болох нөхцөл байдал бас ажиглагдах боллоо. Энэ нь уг хуулийн зарим зүйл заалт, түүний дотор хэдхэн жилийн өмнө оруулсан хэсэг бусад өөрчлөлт нь нийгэмд шинээр бий болсон нөхцөл байдлыг зохицуулах чадамжгүй, түүний дотор зарим зүйл, заалт хэрэгжихгүй байх, эсвэл эдгээрийг зөрчих, үл тоомсорлох явдал газар авах болсон, Үндсэн хуультай зөрчилдсөн хууль, тогтоомж гаргах, бусад хууль болон төрийн захиргааны зарим төв байгууллагын эрх зүйн акт, энэ хуульд нийцсэн байх ёстой зарчим алдагдаж байгаа зэргээс харагдаж байна. Үүнээс гадна Үндсэн хуулийг хатуу баримтлах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ төдийлөн үр дүнд хүрэхгүй байх, үүнээс үүдэн энэ хуулийг дахин засварлах, өөрчлөх санаархал гарч ирэх магадлал ч өндөр байна.
- Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, ОБЕГ, дотоодын цэрэг, тагнуул зэрэг төрийн цэргийн байгууллагууд, түүнчлэн цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон төрийн тусгай хамгаалалт зэрэг байгууллагын шинэчлэлийн үйл явц удаашралтай, санхүүжилт нь хүрэлцэхгүй, үйл ажиллагааных нь онол, эрх зүйн үндэслэл боловсронгуй бус хэвээр байна. Энэ нь хүчний гэж нэрлэгддэг эдгээр байгууллагад удирдлага, зохион байгуулалт, нийгмийн хамгаалал, баталгаа, ажиллагааны болон байлдааны бэлтгэл доогуур, орчин үеийн зэвсэг, тусгай техникийн хангалт муу байгаа зэргээр илэрч, эдгээр нь олны дунд гарах байнгын шүүмжлэл дагуулсаар байна.

- Хууль хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нь гарч буй ноцтой дутагдлын нэг нь хэрэг, маргааныг шийдвэрлэх үйл явцын шударга, тэгш байх зарчим алдагдаж, дуулиант том хэрэг шийдвэрлэгдэхгүй байх, хэрэгсэхгүй болгох, мөрдөн байцаалтыг сунжруулж, цаг хожин хөөн хэлэлцэх хугацаа дуусахыг зориудаар хүлээх, эрүүдэн шүүх зэрэг явдал гарч байна. Үүнээс шалтгаалан иргэдийн зүгээс хууль сахиулах байгууллагуудад итгэх итгэл улам бүр алдрах болж улмаар шүүх, прокурор, авлигатай тэмцэх болон цагдаагийн байгууллагын эсрэг жагсаал цуглаан хийх, шийдвэрийг нь үл зөвшөөрөх явдал хэвийн үзэгдэл болох төлөвтэй байна.
- Эх орноороо бахархах үзэл бүдгэрч бүхэлдээ гутранги, идэвхгүй сэтгэлгээ нийгэмд ноёрхох, гадаад улс оронд ажиллаж, амьдрах хүсэл эрмэлзэл нийт хүн ам, ялангуяа залуучуудын дунд түгээмэл болох хандлага ажиглагдаж байна. Түүнчлэн нийгмийн эмх замбараагүй байдал үүсэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хуулийн бус арга хэрэгслийг хүсэмжлэх уур амьсгал бий болох, улмаар нийгмийн тодорхой хэсэг бүлгийн зүгээс төрийн эсрэг үймээн дэгдээх санаархал үүсэх, үүнийг дэмжих, дэвэргэх зорилго бүхий дотоод, гадаадын ашиг сонирхлын тодорхой бүлгүүдийн ивээлд тулгуурласан улс төрийн хүч гарч ирэх магадлал ч байна.
- Үндэстэн ястны талаар баримтлах бодлогод зарим талаар алдаа гарсаар байгаа буюу иргэдийн дунд үндэс угсаагаа хэт дөвийлгөх үзэл газар авах, бурхны шашны нэр хүнд унах, мөн шашны шинэ урсгалуудыг хяналтгүй нэвтрүүлэх зэрэг нь сүсэгтэн хоорондын зөрчил сөргөлдөөн үүсгэх, үндэстэн, ястны хэт даврах үзэл санааг хүчтэй болгох, энэ үндсэн дээр элдэв төрлийн зөрчил сөргөлдөөн гарах нөхцөлийг бий болгох төлөвтэй байна.
- Олон улсын терроризм улам бүр газар авч Төв Ази, Хятадын Шинжаанд тархаж байгаагийн болон манай улс терроризмын эсрэг барууны эвсэлд нэгдсэнд дургүйцсэн гадны хүчний явуулгын улмаас энэ аюул ямар нэг хэлбэрээр Монгол Улсад орж ирж болох нь мэдрэгдэх боллоо.

Эдийн засгийн салбарт:

- Төр засаг гадаадын өр зээлд ихээр татагдан орж, валютын нөөцөө алдах, барьцаалуулах магадлал ихээхэн өндөр болоод байгаа явдал юм. Ялангуяа Монгол Улсын хөгжилд гадаадын зээл, тусламжийн гүйцэтгэх үүрэг урт удаан хугацаанд өндөр байсан бөгөөд түүний үүргийг хэтрүүлэн үнэлэх, зээл тусламжийн үр өгөөжийг бага анхаардаг байдал монголчуудад нийтлэг ажиглагддаг болно.
- Монгол Улсын дотоод тогтворгүй байдлын улмаас гадаадын аливаа зээл, тусламжийг замаас нь хамтран завших явдал нэлээд гарч байгаагаас үүдэн гадаадын орнууд, түүний дотор том гүрнүүд энэ төрлийн үйл ажиллагаанаасаа татгалзаж болох юм. Энд Монголд ихээхэн газар авч буй бүх шатны авлигын асуудал голлох шалтгаан болж байна гэж мэргэжилтнүүд үзэж байна.
- Цахилгаан эрчим хүчний хангалт, эрчим хүчний эх үүсвэрийн импортоор

Монгол Улс нэг улсаас ихээхэн хараат байдалд байгаа нь ямар нэг шалтгаанаар энэ үйл ажиллагаа тасалдахад Монгол Улсын эдийн засгийн хэвийн үйл ажиллагаа бүхэлдээ алдагдаж болох талтай юм.

- Урт хугацааны зээл, буцалтгүй тусламж нэрийн дор гадаадын санхүүгийн эх үүсвэрийг хэт их хэмжээгээр татан төвлөрүүлэх явдал нэмэгдэж, улмаар өрийн дарамт хяналтаас гарах эрсдэл улам өсөж байна.
- Эдийн засгийг төрөөс удирдан зохицуулах, түүний дотор гадаадын хөрөнгө оруулалтыг тэнцвэржүүлэх төрийн бодлого алдагдах, үүнээс үүдэн улсын хөгжил удаашрах, зогсонги байдалд орох магадлал өндөр байна.
- Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт саарах, хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, эрэлт шаардлагыг хангах эдийн засгийн чадавх буурах, хөрөнгө оруулалт, инновацын үйл ажиллагаа болон шинжлэх ухаан, технологийн хөгжлийн чадамж сулрах, мөн газар тариалан, бэлчээрийн мал аж ахуй зэрэг уламжлалт салбаруудын үр ашиг буурах нь эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн нэг болж болзошгүй юм. Түүнчлэн банкны тогтолцооны тэнцвэр алдагдах, дотоод ба гадаад өр нэмэгдэх, экспортын нийлүүлэлтэд уул уурхай, түүхий эдийн бүтээгдэхүүн тоног төхөөрөмж, хүнс, ахуйн хэрэглээ, үүний дотор өргөн хэрэглээний барааны импорт хэт давамгайлсан хэвээр байна.
- Эдийн засаг дахь сөрөг үйл явцаас үүдэн хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа өсөн нэмэгдэж байна. Энэ нь улс төрийн тогтворгүй байдал үүсэх, манай орны эдийн засгийн нэгдмэл орон зай буюу үйлдвэрлэл-технологи, тээврийн хэлхээ холбоо, санхүү-банк, зээл, татварын систем сулрах, цаашлаад улс орны хөгжлийн нэгдмэл орон зай алдагдахад хүргэж болзошгүй байна.
- Банк санхүүгийн хүрээнд үүссэн зөрчил сөргөлдөөн, гажуудал, түүний дотор мөнгөний бодлого, валютын зах зээлийн хямрал гүнзгийрч, энэ салбар дампууралд орох, улмаар Монгол Улсын банк, санхүүгийн үйл ажиллагаанд итгэх гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн итгэл эрс сулрах төлөвтэй байна.
- Сайтар тооцоогүй, эдийн засгийн өсөлтөөр баталгаажаагүй зээл тусламж, үнэт цаасны болон тоон валютын зах зээл өргөжих, үүнээс үүдэн төр засаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэд өрөнд ихээр орж, улс орон валютын нөөцөө алдах, барьцаалуулах, гадаад дотоодын хөрөнгө оруулалтын тэнцвэр алдагдах, түүнчлэн зээл, тусламжийг замаас нь завших явдал газар авснаас үүдэн гадаад орнууд, түүний дотор том гүрнүүд энэ төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээ зогсоох магадлал нэмэгдсээр байна.
- Бүх шатны сонгуультай уялдаатайгаар бодитой үндэслэл, цэгцтэй бодлогод тулгуурлаагүй хэт задгай нийгмийн халамж, төрийн байгууллагуудын үндэслэл муутай их зарлага, нэгдсэн зохицуулалтаар төлөвлөгдөөгүй, тархай бутархай, үрэлгэн хөрөнгө оруулалт зэрэг нэмэгдэх, эдгээрээс үүдэн үнийн хөөрөгдөлт үүсэж, инфляц хяналтаас гарах, төгрөгийн ханш

огцом ихээр унах, эдгээр нь Олон улсын валютын сантай байгуулсан гэрээ, хэлэлцээр зөрчигдөхөд хүргэх, улмаар энэ гэрээг зогсоох магадлал бий болоод байна.

- Үйлдвэржилт болон хүн амын өсөлт нэмэгдэх, хотжилт өргөжихийн хэрээр эрс өсөж буй хэрэгцээг амиа аргацаасан бэлчээрийн мал аж ахуй, эрсдэлээс хамгаалагдаагүй, усалгаагүй, техник, технологи, менежментийн хувьд ихээхэн хоцрогдсон газар тариалан хоёр гүйцэхгүй байгаагаас үүдэн хүнсний болон өргөн хэрэгцээний барааны импорт тогтмол нэмэгдэж, энэ салбарт импорт, экспортын тэнцвэр их хэмжээгээр алдагдахад хүрээд байна.
- Эрчимтэй мал аж ахуй, усалгаатай газар тариалан болон уул уурхайг хөгжүүлэх зэрэг сайхан нэрийн дор гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын зүгээс улсын газар нутгийн аль сайныг нь сорчлон эзэмшихийг эрмэлзэх явдал газар авах, улмаар бэлчээр хумигдаж уламжлалт нүүдлийн мал аж ахуй оршин тогтноход хэцүү байдал үүсэх, энэ нь нийгмийн, юуны өмнө малчдын болон орон нутгийн иргэдийн хүчтэй бухимдлыг бий болгож магадгүй байна.
- Төрийн хяналт суларч, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, үр дагаврыг нь арилгах эрх зүйн болон эдийн засгийн үр нөлөө бүхий механизм бүрэн бий болоогүй байгаа нь аж ахуйн үйл ажиллагааны бүхий л салбарт техникийн чанартай том осол, сүйрэл гарах эрсдэлийг нэмэгдүүлэх боллоо.

Нийгмийн салбарт:

- Монгол Улсын хөгжил, түүний дотор нийгэм, эдийн засаг, иргэдийн амьдралын түвшин гадаадын дэмжлэг, зээл, тусламжаас ихээхэн шалтгаалсан хэвээр байгаа нь эцсийн дүндээ нийгмийн амьдралд учирч болох аюул заналыг магадлал өндөртэй болгож байна. Ийм байдал бусад буурай хөгжилтэй орнуудын хувьд бараг хэвийн үзэгдэл боловч хүн ам багатай Монголын хувьд илүү уршигтай байж болох юм.
- - Монгол Улсын гадаад харилцаа улам бүр өргөжиж хүн, мал, эд хөрөнгийн урсгал чөлөөтэй болох тусам түүнийг дагалдан элдэв халдварт өвчин тархах аюул бодитой болж байгаа юм. Үүний дотроос КОВИД-19 маягийн элдэв төрлийн шинэ вируст цар тахал, ДОХ-ын болон малын халдварт өвчний аюул улсын хилээр нэвтрэн орж ирж буй асуудлыг үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болох хүчин зүйлийн түвшинд авч үзэх шаардлагатай болж байна.
- Орлогын тэгш бус байдал гүнзгийрч, нийгэм эдийн засгийн хувьд цөөн тооны чинээлэг бүлэг болон амьжиргааны түвшин доогуур олонхын хооронд ялгарал нэмэгдэх, ядуурлын түвшнээс доогуур орлоготой хүн амын тоо өсөх, ажилгүйдэл нэмэгдэхийн зэрэгцээ нийгмийн тогтворгүй байдал, түгшүүрийн шинжтэй үзэгдэл газар авах эрсдэлтэй байна. Нийгмийн салбар дахь эдгээр сөрөг үзэгдэл өсөн нэмэгдэх нь үндэсний үнэт зүйлс болон соёл иргэншлийн эрхэмлэх зүйлс үнэгүйдэх, улс орны оюун ухааны болон үйлдвэрлэлийн

чадавх буурах, хүн амын боловсрол доройтох, оюун санааны болон эдийн засгийн хөгжлийн үндсэн эх үүсвэр хомсдоход хүргэж болзошгүй юм.

- Улс орныг жигд, тэнцвэртэй, бүхэнд хүртээмжтэй хөгжүүлэх бодлого алдагдсаны улмаас хот, хөдөөгийн иргэд хоорондын харилцаа хурцдахад хүрч, улс орны төрийн байгуулал, нийгэм-эдийн засгийн нэгдсэн тогтолцоонд ноцтой аюул учруулах магадлалтай байна. Нийгмийн гүн гүнзгий хямралын үр дагавар нь хотын хүн амын дунд төрөлт буурах, дундаж наслалт төдийлөн нэмэгдэхгүй байх, нийгмийн болон хүн амын бүтэц бүрэлдэхүүн гажилтад орох, үйлдвэрлэлийн хөгжлийн үндэс болсон хөдөлмөрийн нөөц алдагдах, нийгмийн суурь нэгж болох гэр бүлийн тогтвортой байдал сулрах, хувь хүмүүсийн ёс суртахуун, оюун санаа, бүтээлч чадавх буурах, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын систем хямралд орох, архи, мансууруулах бодисын хэрэглээ, өвчин зовлон эрс нэмэгдэх зэргээр илэрч байна.
- Нийгэм, эдийн засгийн хөгжил удаашрах, шударга бус байдал газар авах гэх мэт олон шалтгаанаар хууль ёсыг дээдлэн хүндлэх монгол сэтгэлгээ алдагдах, үүнээс үүдэн төр суларч, нийгмийн эмх замбараагүй байдал үүсэх, ард түмний түр зөвлөл байгуулах гэх мэт нэрийн дор иргэдийн чөлөөт сонголтоор байгуулагдсан төр, засгийг Үндсэн хуулийн бус аргаар огцруулахыг хүсэмжлэх үзэгдэл нийтийн дунд газар авах болоод байна.
- Улсын хөрөнгийг завшсан олон том хэргийн ар талд байсан буюу нэр холбогдсон улс төрчдийг УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэхгүй, төрийн удирдах албан тушаалд томилохгүй байхыг шаардсан олон нийтийн эсэргүүцэл улам бүр нэмэгдэх шинжтэй байна.
- Хүн амын тодорхой хэсэг нь оюун санаа, эрүүл мэндийн доройтлын хэмжээнд хүрэхүйц ядууралд орох, боловсролын салбар хоцрогдолд нэрвэгдэх, гэрчилгээ дипломтой боловч мэдлэг боловсролгүй хүмүүс олшрох, иргэдээ эрүүлжүүлэх, гэгээрүүлэх замаар улс орны чанар, чансааг сайжруулах бодлогын хэрэгжилт удаашрах, тасалдах, хүүхэд залуучуудын хүмүүжил доройтож нийгэмд хувиа хичээгсэд, гэмт хэрэгтнүүдийн болон гадаадад гарсан, мөн гарахыг хүсэмжлэгчдийн тоо хэмжээнээс хэтэртэл өсөх, энэ нь гадаадын ажилчдын тоо аргагүйн эрхэнд нэмэгдэхэд хүргэх, үүнээс үүдэн нийгмийн дотор тэднийг гадуурхах үзэгдэл газар авч хөрш оронтой харилцаа муудах шинэ шалтгаан үүсэх төлөвтэй байна.
- Нийгмийн харилцаа гэмт хэрэгжих аюул занал онц хурцаар нэмэгдэж байна. Эдийн засаг, хууль сахиулах байгууллагад гарч буй алдаа завхрал, төрийн зохицуулалт, хяналтын тогтолцооны үйл ажиллагаа эмх замбараагаа алдсан, эрх зүйн бааз нь боловсронгуй бус, төрийн зүгээс хэрэгжүүлэх нийгмийн оновчтой, шударга бодлого үгүйлэгдэх болсон, нийт иргэдийн оюун санаа-ёс суртахууны чадавх буурсан зэрэг нь улс оронд гэмт хэрэг, авлига газар авах, нийгмийн хэт давсарсан үзэгдэл дэлгэрэхэд хүргэж магадгүй байна. Энэ нь Үндсэн хууль болон бусад хуулийн хэрэгжилтэд тавих эрх зүйн хяналт суларч, гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалын

зарим элемент гэмт хэргийн бүтэцтэй хэлхээ холбоотой болж, тэд банк, санхүүгийн салбар, томоохон үйлдвэр, худалдааны болон бараа нийлүүлэх сүлжээнд нэвтэрч байгаагаар илэрч байна. Тиймээс гэмт хэрэг, авлигатай хийх тэмцэл нь эрх зүйнхээс гадна улам бүр нийгэм, улс төрийн шинж чанартай болсоор байна.

- Улс орны хэмжээнд эрүүгийн нөхцөл байдал хяналтаас гарах, зохион байгуулалттай болон үндэстэн дамжсан гэмт хэргийн том бүлэглэлүүд бий болох, манай улсын нутаг дэвсгэрийг мансууруулах бодис, элдэв төрлийн зэвсэг, цөмийн түүхий эд, материал, хүн худалдаалахаар зөөвөрлөх, дамжуулах талбар болгох гэсэн оролдлого гарах, тэдгээрийн хор уршиг нь улс орны улс төр, эдийн засгийн бодлогод нөлөөлөх хэмжээнд хүрэх магадлал өндөр байна.
- Хар тамхи, мансууруулах төрлийн бусад бодисын хэрэглээ, ялангуяа залуучуудын дунд хяналтаас гарах, ийм төрлийн бодисын тээвэрлэлт, түгээлт, сурталчилгаа, тараалт, худалдаа нь зохион байгуулалттай гэмт хэргийн хэлбэрт орох төлөвтэй байна.
- Сүүлийн жилүүдэд янз бүрийн шалтгаанаар эх орноо батлан хамгаалах болон төрийн хууль ёсыг дээдлэн хүндлэх монгол сэтгэлгээ алдагдаж, улс орны батлан хамгаалах тогтолцоо, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаа хямралд орж магадгүй байдал ажиглагдах боллоо. Энэ нь Монгол Улсын тусгаар тогтнолын баталгааны билэг тэмдэг, хүчин зүйлсийн нэр хүнд суларч эцсийн дүндээ төрийг хүчгүйдүүлэх, эмх замбараагүй байдал бий болоход хүргэж болзошгүй юм.

Соёл иргэнийлийн салбарт:

- Монгол Улсын гадаад харилцаа өргөжих, нээлттэй болохын хэрээр бусад орны, юуны түрүүнд америк, солонгос, хятад маягийн амьдрах хэв маяг, эрхэмлэх үнэт зүйлсийн хүчтэй нэвтрэлт гүнзгийрэх, үүнээс үүдэн үндэсний үнэт зүйлсийн үнэлэмжид эргэж буцалтгүй өөрчлөлт гарах, энэ нь монгол хүний удмын сан, угсаа гарваль, төрөлх хэлэнд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.
- Хүн төрөлхтний нийтлэг соёлыг дээдлэх, бусад шашныг хүндэтгэх, зарим тохиолдолд албан ёсны бус христийн шашны урсгалд автах үзэл болон монгол үндэстний төрөлх хэл, соёл, бурхны шашин, ёс заншил, удмын сан, угсаа гарвалиа хадгалан хамгаалах гэсэн эрмэлзлийн хооронд зөрчил, сөргөлдөөн үүсэх, энэ нь улс төржих замаар нийгэмд хуваагдмал байдал үүсгэх магадлал улам бүр нэмэгдсээр байна.

Байгаль орчны салбарт:

- Дэлхийн цаг уурын дулаарал, өөрчлөлт болон бусад шалтгаанаас үүдэн байгалийн гамшигт үзэгдлүүд олшрох, энэ нь улс орны эдийн засаг, нийгэмд дааж давшгүй хохирол учруулж магадгүй байна.

- Монгол Улс шилжилтийн эмзэг эдийн засагтай орон бөгөөд гадаадын зээл, тусламжид дулдуйдсан, бусад улсын геополитикийн өрсөлдөөний золиос болсон хөгжлийн явцад манай орны харьцангуй сайн хадгалагдан үлдсэн онгон байгалийн тэнцвэр алдагдах аюул бодитой юм. Тухайлбал: ус, гол мөрөн, агаар мандал, хөрс бохирдох, ой сүйдэх, газрын талхидал, цөлжилт өнөөдөр түгшүүр дэгдээсэн том асуудал болон хувирч байна. Үүнээс газар эдийн засгийн зохицуулалтад ороогүйгээс бэлчээрийн талхидал, хомсдол байгалийн гамшгийн хэмжээнд хүрэх аюултай болж, дээр нь ган, зуд тогтмол нүүрлэх болсон нь хүн амын нэлээд хэсгийн амьжиргааны эх үүсвэр болсон мал аж ахуй, газар тариаланд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрч болох талтай байна.
- Байгалийн нөөц, газрын гүний баялаг шавхагдах, экологийн нөхцөл байдал муудах зэрэг нь улс орны эдийн засгийн хөгжлийн түвшин ихээхэн доогуур, дээрх асуудлуудын ноцтой шинж чанар болон ач холбогдлыг ухамсарлахад нийгэм төдийлөн бэлэн бус байгааг шууд харуулах боллоо. Энэ нь аж үйлдвэрлэл зөвхөн уул уурхайн салбарт түшиглэсэн, байгаль хамгаалах хууль тогтоомжийн үндэс сул хөгжсөн, эсвэл тодорхой технологи байхгүй, байсан ч бараг ашигладаггүй, экологийн соёл сул дорой байгаагаар холбоотой байна. Ядуу буурай улс орны нутаг дэвсгэрийг цөмийн хаягдал болон байгаль орчинд хор хөнөөлтэй бусад материалыг булшлахад ашиглах хандлага чиг бий болж байна.
- Эдийн засгийн хөгжил, түүний дотор уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэлийг эрчимжүүлэх явцад байгалийн тэнцвэр алдагдах, ус, гол мөрөн, агаар мандал, хөрс бохирдох, ой сүйдэх, цөлжилт газар авах, бэлчээрийн талхидал, тариалангийн талбайн хомсдол ихсэх, түүнчлэн бэлчээрийг хувьчлах, хамгийн таатай нутаг оронд эрчимтэй мал аж ахуй, газар тариаланг өргөжүүлэхийг хэт улайрах, эдгээрээс үүдэн хүн амын нэлээд хэсгийн амьжиргааны эх үүсвэр болсон мал аж ахуй, газар тариалангийн хөгжил зогсонги байдалд орох, өөр хоорондоо тэрсэлдэх төлөвтэй байна.
- Үйлдвэрлэлийн болон хүний бусад үйл ажиллагааны хариуцлагагүй, эмх замбараагүй байдлаас үүдэн байгаль орчинд бүхэлд нь ноцтой хохирол учрах, зарим газар нутагт дахин нөхөн сэргээгдэх бололцоогүй байдалд хүрэх шинжтэй байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал нь дан ганц гадаад орчинд гарсан өөрчлөлтөөс бус Монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний дотоод хувиралтаас ихээхэн шалтгаалж байна. Манай орны төр, нийгмийн шинэчлэл бүрэн дүүрэн дуусаагүй, эдийн засаг, нийгмийн зарим салбарт хямралт байдал үргэлжилсээр, ядуурал, авлига, нийгмийн шударга бус явдал газар авч, эдгээрээс үүдэлтэй бухимдал хадгалагдсаар байна. Улсын хөгжлийн зарим салбар зогсонги байдалд удаан байх, төрд хямрал, нийгмийн ухамсарт тогтворгүй байдал давамгайлах нь өнөөдөр магадгүй гадны аюулаас ч илүү эрсдэл учруулж болзошгүй хүчин зүйл гэж иллогдох боллоо.

Төгсгөлд нь эдгээрийг нэгтгэн дүгнэхэд, өнөө үед манай орны үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй дотоодын үүдэл, сэдэл бүхий, цөөнгүй тооны шинэ, эрсдэл, сорилт, бий болсоор байгаа нь үндэсний аюулгүй байдлын салбарт төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагаанд тодорхой хэмжээний өөрчлөлт хийх цаг болсныг харуулж байна.

On some internal factors that may affect national security

Myagmar Dovchin

Prof, Dr (Sc.D), Head of the Expert Group, igsmyagmar@gmail.com
National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Abstract

Mongolia has made significant progress in its transition to a democratic society founded on the principles of democracy, a market economy, human rights, and fundamental freedoms. Although the country has gradually developed and strengthened its national security system, progress has been slower than anticipated.

Despite these achievements, Mongolia has yet to establish an effective mechanism for integrating national security policy into broader state policy and for systematically monitoring and evaluating its implementation. At the same time, both the external and internal security environment surrounding Mongolia, as well as the theory and practice of military affairs, have undergone profound transformations. These changes have accelerated in recent years, creating an increasingly complex and uncertain security environment.

In particular, numerous emerging domestic factors have the potential to affect Mongolia's national security in new and significant ways. These developments underscore the urgent need to review and update the National Security Concept of Mongolia, adopted in 2010. As part of this process, it is essential to comprehensively examine, identify, analyze, and assess both external and internal conditions and factors that may influence the country's national security, thereby ensuring that Mongolia's security policy remains relevant and responsive to contemporary challenges.

Keywords: National security policy; National security system; Internal security; Security factors; Security legislation; Defense policy; Military security

Received: June 05, 2026 | Accepted: June 19, 2026 | Published online: July 07, 2026



© The Author(s) 2026
<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.